



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн  
өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг  
чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” төрийн өмчит хувьцаат компанийг татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүн Зам, тээврийн хөгжлийн яамны хэлтсийн дарга Х.Оргил-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Гийвийшинэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Б.Марс-Од, Г.Туул, Т.Хулан, Ч.Мөнхзаяа, хараат бус гишүүн Т.Туул, Г.Түвшинжаргал, Г.Сүхээ нарыг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРСИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ